

# ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ХОТЫГ ТОДОРХОЙЛСОН СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮН

*Я.Байгалмаа, доктор (Ph.D)  
Монголын үндэсний их сургууль*

*Б. Долгор  
Доктор (Ph. D.), профессор  
Шинжлэх ухаан, технологийн их сургууль  
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль  
dolgor@must.edu.mn*

**Хураангуй.** Хүүхдэд ээлтэй хотыг хөгжүүлэх талаар олон орны судлаачид судалж, хүүхдэд ээлтэй хотыг үнэлэх аргачлал, шалгуур үзүүлэлтүүд гаргаж, хотоо хүүхдэд ээлтэй болгон хөгжүүлсэн олон сайн туршлагауд бий болсон. Мманай орны хувьд салбарын байгууллагууд “хүүхдэд ээлтэй эмнэлэг”, “хүүхдэд ээлтэй сургууль”, “хүүхдэд ээлтэй цэцэрлэг”-ийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг боловсруулан гаргасан байна. Улаанбаатар хотын хувьд эрүүл аюулгүй байдлын индексийг бүх дүүрэг, хороогоор гаргаж, “Ухаалаг Улаанбаатар”, “Найрсаг Улаанбаатар”, “Аз жаргалтай Улаанбаатар” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирсэн. 1990 оноос хойш нийслэлд хөдөө орон нутгаас 590.0 мянга орчим хүн шилжин ирж, эдийн засаг, нийгэм, үйлдвэрлэл, үйлчилгээ, бизнесийн хөгжил хотод илүү төвлөрсөн, хот хөдөөгийн ялгаа эрс ихсэж, иргэдийн амьдрах орчны сонголт хийхэд нь нөлөөлөхүйц хэмжээнд байгаатай холбоотой ажээ. УБ хотын хүн ам өсөхийн хэрээр агаар, ус, хөрсний болон орчны бохирдол нэмэгдэж байгаа нь хүүхдийн эндэгдэл, өвчлөл нэмэгдэх шалтгаан болж байна. Гэтэл жилд 120 хүүхэд, 1200-1300 том хүн агаарын бохирдлын шалтгаантайгаар өвдөж, нас барж байна<sup>3</sup>. Улаанбаатар хотын агаарыг гэр хорооллын галлагаатай зуух, замын хөдөлгөөн, аж үйлдвэрээс ялгарч буй бодис, газрын гадаргуугийн хуурай нөхцөлд салхины улмаас агаарт дэгдэж буй бохирдол, авто тээврийн хэрэгслийн утаа хамгийн ихээр бохирдуулж байна (Дэлхийн банк, 2009). Хүн амын энэхүү өсөлт нь хот байгуулалт, төлөвлөлт, байгаль орчин, экологийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, төлөвлөлтгүй суурьшил бий болох, гэмт хэрэг, зөрчил ихсэх, замын хөдөлгөөнд хэт түгжрэл үүсэх, хүн амын эрүүл мэнд, нийгмийн халамж, үйлчилгээний салбар доголдох зэргээр эдийн засаг, нийгмийн бүх талын харилцаанд хүндрэл учруулах болсон. Хотын агаар, орчныг бохирдуулагч өөр эх үүсвэр нь тээврийн хэрэгсэл юм. Сүүлийн жилүүдэд авто машины тоо эрс нэмэгдэж, автозамын сүлжээ нь хязгаарлагдмал, төв гудамжууд нь байнга замын түгжрэлтэй байдаг болсон. Дэлхийн хотууд хөгжлийн чиг баримжаагаа өөрчилж, хүний эрх, эрх чөлөө, соёл, эрх тэгш байдлыг хүндэтгэсэн, хүүхэд өсвөр үеийнхний онцлог хэрэгцээг анхаарч бүх нийтээр хүүхдээ хайрлан хүндэтгэсэн, хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлсэн хотыг хөгжүүлэхийг зорих болжээ.

**Түлхүүр үгс:** Хүүхдийн эрх, аюулгүй байдал, хамгаалал, оролцоо, хүүхдэд ээлтэй байдал

## I. УДИРТГАЛ ХЭСЭГ

Улс орны ард иргэдийн аюулгүй байдал, нийгэм ахуйн хангамж, хэрэгцээ, хэрэглээний түвшин, сэтгэл ханамж, үнэлэмжээс өнөөгийн нийгмийн хөгжлийн төлөв байдал бүхэлдээ хамаарч байгаа өнөө цагт хот, орон нутаг нь

---

<sup>3</sup> АШУИС, АНУ-ын Берkeley дэх Калифорнийн их сургууль, БНСУ-ын Сөүлийн Үндэсний их сургуулийн хамтарсан судалгаа 2017

хүүхдэд ээлтэй байх нь улс үндэстний хөгжлийн илэрхийлэл, үзэл баримтлал болжээ. (НҮБХС, 1997) Хүүхдэд ээлтэй байх асуудал дэлхийн, улс үндэсний, бүс нутгийн түвшинд сүүлийн арван жилийн туршид яригдаж байгаа бөгөөд энэ нь хүүхдийн сайн сайхан байдлыг хангах хамгийн чухал үзүүлэлт юм. (НҮБ-ын Хүн амын нутаг суурьшлын газар, 1996)

Өнгөрсөн хугацаанд манай оронд зах зээлийн эрэлт хэрэгцээ, эдийн засгийн хөгжлийг хангахад чиглэсэн замбараагүй хотжилт өрнөж, нийтийн эрх ашгийг хангах асуудал, тэр дундаа хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах асуудлууд орхигдож иржээ. 2015 оноос хойш хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн олон хууль тогтоомж, хөтөлбөрийг баталж, тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийг хийсэн хэдий ч төрөөс явуулж буй бодлого, үйл ажиллагаа, нийгмийн суурь үйлчилгээ бүх хүүхдэд тэгш, хүртээмжтэй хүрч чадахгүй байсаар байна. Дэлхий дахинаараа хот суурин газрыг хүүхдэд ээлтэй болгон хөгжүүлэхийг зорих болсон энэ цаг үед хүн ам төвлөрсөн, орчин үеийн метрополис хотын хувьд олон улсын жишигт нийцсэн хот болохын тулд хүүхдэд ээлтэй байдлыг эн тэргүүнд судлах шаардлагатай байгаа нь энэхүү сэдвийг сонгох үндэслэл болсон. Хүүхдийн онцлог хэрэгцээг анхаарч, хотын хүүхдэд үзүүлэх сөрөг нөлөө, тэгш бус ялгаатай байдлыг бууруулах, хүүхдэд үзүүлэх нийгмийн суурь үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, тэдний өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх зэрэг шаардлагаас улбаалан *хотыг хүүхдэд ээлтэй болгон хөгжүүлэх* хандлага урган гарчээ.<sup>4</sup>

Глийсон (Gleeson, 2006) хүүхдэд ээлтэй байх нь хотжилтын явцад хүүхэд, залуучуудын эрүүл эсэн мэнд, амьдрах таатай нөхцөлийн шийдэл болж байна. Хот суурин газарт амьдарч буй хүүхдийн эрх ашигт хамаатай засаглалын бүх үйл ажиллагааг хамарч, хүүхдийн эрхийг хангаж ажиллах сайн засаглалыг хөгжүүлэхэд чиглэнэ. Малоне К (Malone K, 2006) хүүхдэд ээлтэй хотын гол шинж чанар бол хотын хөгжлийн бодлого, шийдвэрт хүүхдийн санаа бодол, хэрэгцээ шаардлага туссан байх төдийгүй, тэднийг нийгэм соёлын арга хэмжээнд оролцуулах, эрүүл мэнд, боловсрол, халамж хамгааллын үйлчилгээг бүрэн тэгш хүртээх, хүүхэд бүрт цэвэр ундны усны хангамж, ариун цэврийн нөхцөл боломжоор хангах, хүүхдүүд гудамжаар айх аюулгүй явах, найз нөхөдтэйгээ уулзах, тоглох, амьд ургамал, амьтан байгаль орчны таатай нөхцөлд цэвэр агаар, бохирлогдоогүй орчинд амьдрах, яс үндэс, угсаа гарал, хүйс, шашин шүтлэг үл харгалзан ур чадвараа хөгжүүлэх өргөн боломжийг бүрдүүлсэн байх явдал юм.

---

<sup>4</sup> Innocenti Research Centre, UNICEF, Building Child Friendly Cities, 2004

## II. ОНОЛ АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Хүүхдэд ээлтэй хотын тухай асуудал нийгмийн шинжлэх ухааны төдийгүй, улс орон, хот, орон нутгийн хөгжлийн гол асуудал болж ирсэн тул эл асуудлыг эрдэмтэн судлаачид олон талаас нь анхааран судалсан байдаг. 1930 онд хийсэн судалгаагаар хүүхдүүдийн эрүүл мэндийн нөхцөл байдал ерөнхийдөө сайнгүй байгааг хоол тэжээлийн дуталтай бас хүүхдийн тураалтай холбоотой байна гэж тайлбарласан. (McNeill, 1931). “Хүүхдийн гаргадаг зан ааш, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаас үүдэлтэй байж болох юм” гэсэн санааг судлаач Бернард (1939), Макдональдс, Карсон, Хавжир нар (1949) гаргасан. 1960-аад оны дундуур Их Британид хот орчны талаарх хүүхдийн сэтгэл ханамжийг судалжээ. Энэ судалгаагаар хүүхдийн тоглоомын талбай, замын ойр орчин ба хөрш зэргэлдээ орон сууцны нөхцлийг хамтад нь судалсан. (Маркус, Мүүр, 1976). 1960-аад оны сүүлээр Хермвудын Лейди Аллен “Тоглоом ба төлөвлөлт” гэсэн загварыг боловсруулан хүүхдийн олон төрлийн тоглоом хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилд чухал нөлөөтэй болохыг судалж тайлбарласан байна. (Hurtwood, 1968). Энэ үед хүүхдийн хүмүүжил, төлөвшлийг анхааран, хүүхдийн бие бялдар, сэтгэцийн хөгжил, мөн сэтгэл санаа хүрээлэн буй орчинтой хэрхэн холбоотойг судалжээ. Хүүхдийн аж байдлын судалгаанд тэдний амьдарч буй орон сууцны нөхцөл, орчин, гэр бүлийн хөдөлмөр эрхлэлт зэрэг үзүүлэлтүүдийг авч үзсэн.

Энэ үеэс хүүхдийн хөгжилд орчны нөхцөл байдал чухал болохыг ойлгож, хотын хүүхдийн сайн сайхан байдалд хүрээлэн буй орчин чухал нөлөөтэй гэсэн санааг дэвшүүлсэн судалгаанууд хийгджээ. Судлаач Бремнерийн Чикагод гаргасан загвараас үүдэн, хүүхдийн тоглоомын талбай, чөлөөт цагийн орчиныг хөгжүүлэх загварууд гарч эхэлсэн. Эндээс “хот суурин газар, хүрээлэн буй орчны бодлогыг төлөвлөн хэрэгжүүлэхдээ хүүхдийн хөгжил, онцлог хэрэгцээг заавал анхаарч үзэх ёстой” гэсэн соёл, хандлагыг нийгэмд бий болгосон байна. (Gatley, 2005).

1970 -1990 онуудад хамтарсан багийн аргачлалууд дэлгэрсэн. Судлаачид, архитекторчид, төлөвлөгч нар болон хүрээлэн буй орчны мэргэжилтнүүд оролцсон Interdisciplinary Approach буюу харилцан хамтрах аргачлалыг гаргаж, "өсвөр ба бага насныхныг зорилтот бүлэг болгон тэдний амьдардаг орчинг үнэлэх" ажлыг зохион байгуулсан. (Lynch, 1977). Энэ судалгаа нь “Хотод өсөж том болох нь” нэртэй бөгөөд хүүхдүүд олноороо тоглох газар, ямар ч албадлагагүйгээр цугларч уулздаг, тоглодог, ярилцдаг, зугаалдаг, чөлөөт цагаа өнгөрүүлдэг газрууд болон тэдний амьдардаг гудамж, хашаа, хонгил зэргийг тогтоох, мөн тэдний хотоор явдаг, хэдэн төгрөг унааны хөлс болгон зарцуулдаг, эцэг эх нь хяналт тавьдаг эсэх, хүүхэд ирж

очих газраа сайн мэддэг эсэх, айх айдасгүй, аюулгүй хөдөлгөөнд оролцдог эсэх талаар мэдэхэд чиглэгдсэн. Уг судалгаа нь хот суурин газрын хүүхдүүдийн нөхцөл байдлыг ойлгоход чухал хувь нэмэр оруулсан байна. (Matt Moore & Young, 1978).

1980-аад оны дунд үеэс хүүхдийн бие бялдрын хөгжилд байгаль орчны, нийгмийн сэтгэл зүйн нөлөөг түлхүү анхаарч эхэлсэн байна. Судлаач Берг, Медрич нар хүүхдийн тоглоомын төрөл хэлбэр, тоглож байгаа тоглоомын талбай болон нийгмийн харилцаа, хүрээлэн буй орчны нөлөөг олж мэдэхэд анхаарал хандуулсан байдаг. (Berg & Medrich, 1980); Хомел, Бёрнс нар хотын болон хотын захын хүүхдүүдийн хүрээлэн буй орчны ялгааг харж, тэр нь хүүхдэд хэрэхэн ойлгогдож, хүртээмжтэй байгаад ажиглалт хийсэн. (Homel & Burns, 1989). Судлаач Вард 1978 онд “хот суурин газрын төлөвлөлтөд хүүхдийн оролцоог дэмжих нь нэн чухал” гэсэн санааг дэвшүүлсэн. (Ward, 1978). Энэ үеэс хүүхдийн дуу хоолой, тэдний санал бодлыг анхаарч, бодлогын баримт бичиг боловсруулалтад хүүхэдтэй хамтран ажиллаж эхэлжээ. Дискселл (2002) залуучууд орон нутгийн хөгжлийн үйл явцад хамрагдаж оролцох ёстой гэж үзсэн. Учир нь хотын хөгжилд хүүхдийн оролцоо нь хүүхэд ба насанд хүрэгчдийн аль алиных нь хувьд үр дүнтэй байдаг.

1990-ээд оноос хүүхдийн эрүүл мэнд, тэр дундаа хүүхдийн бие бялдар, оюун ухаан, сэтгэцийн эрүүл мэндийн судалгаанууд нэлээд хийгдсэн байна. Авто машины огцом өсөлтөөс улбаалан, явган хүний зам, дугуй унах, орчин үеийн тээврийн хэрэгслийг сонгох боломжийг судалсан. (Cervero & Duncan, 2003). Судалгаагаар нийгмийн эрүүл мэндийг сайжруулахад явган явах, дугуй унах нь бие бялдар, эрүүл мэндэд сайн нөлөөтэй болохыг харуулжээ. (Дора, 1999). Эрүүл мэндийн ажилтнууд анх удаагаа хот төлөвлөлт, бусад хамаарал бүхий салбарын судлаачидтай хамтран ажиллаж эхэлсэн. (Франк, Энгелке, Шмид, 2004). Түүнчлэн хүүхдийн эрүүл мэнд, орчныг судалдаг олон эрдэмтэн судлаачид хотын хүүхдүүдийн эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөний судалгааг мөн хийсэн. (Burchell & Mukherji, 2003, Frumkin, 2002). Мөн зарим оринā бага насны хүүхдийн таргалалтыā нэмэгдүүлж бāéāāā шалтгааныг тогтоох олон судалгаа хийгдсэнээс судалгааны ихэнх нь хүрээлэн буй орчин, эрүүл мэндийн хоорондын харилцан хамаарлыг судалсан.

2001 онд Кумминс, Жаксон нар “Хүүхдийн таргалалтын шалтгаан нь тэдний хөдөлгөөн хомсдоноос үүдэлтэй тул бие бялдрын хөгжилд хөдөлгөөн чухал хүчин зүйл болж байна” гэдгийг судалгаагаар гарсан. (Cummins and Jackson, 2001)

Дэлхий дахинд, сүүлийн арван жилийн туршид хүүхдэд ээлтэй үндэстэн, бүс нутаг, олон нийт болон хөрш байх үзэл баримтлал түгээмэл болсон. Энэ нь

хүүхдийн сайн сайхан байдлыг хангах хамгийн сайн үзүүлэлт бөгөөд хүүхдэд ээлтэй хөдөлгөөний гол сэдэв юм (UNICEF, 1992, 1997). Хүүхдэд ээлтэй хотыг хөгжүүлэх асуудлыг 2000 оноос нарийвчлан судалж эхэлсэн байна. Судлаач, өмгөөлөгч, хүүхдийн эрхийг хамгаалагч Тим Гил, “Хүүхдийн тоглож наадах ээлтэй орчин” судалгаагаар “хүүхдүүд тоглож наадах, эрх чөлөөтэй байх эсэх нь тэдний амьдран буй орчноос ихээхэн хамаардаг. Хэрэв хүүхдэд тоглож наадах орчныг бүрдүүлээгүй бол тухайн хот, газрын амьдралын чанар, хот төлөвлөлт, аз жаргалын индекс ихээхэн муу байгааг илтгэдэг үзүүлэлт учраас үүнд анхаарлаа хандуулах зайлшгүй шаардлагатай. Тоглож наадах сайхан орчинтой газар нь хүүхдийн эрүүл мэнд, боловсорч хөгжих нөхцөл болдог, салшгүй холбоотой зүйлс юм” гэж дүгнэсэн.

Фүүлкох. Г, Стийв. Ф (Woolcock, G. and Steele, W. ( Towards the development of an indicators framework for a child-friendly community: literature review, 2008) нар хамтарч хүүхдэд ээлтэй хотуудад тавигдах хөгжлийн үндсэн үзүүлэлтүүдийг боловсруулан гаргасан бол Канадын “Хүүхэд залуучуудын нийгэмлэг” -ийн судалгааны хамтарсан баг “хүний амьдралын эхний жилүүдэд анхаарах нь маш чухал” гэсэн санааг дэвшүүлж, орон нутгийг хүүхэд залуучууд өсч хөгжих таатай газар болоход шаардлагатай 17 үндсэн шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, хэрэгжүүлэх аргачлалыг боловсруулсан. Хүүхдийн эрүүл, аюулгүй орчин нь тэдний хөгжил төлөвшилд нэн чухал нөлөө үзүүлэх талаарх судалгааг Бжөрклид. П, Нордстрём. М нар (Björklid, P. and Nordström, M. ( 2007) “Environmental child-friendliness: collaboration and future research, Children, Youth and Environments”), Каттержээ. (Chatterjee, S. ( 2006) “Children’s friendship with place: an exploration of environmental child friendliness of children’s environments in cities”) хотын хүүхдэд хамгийн ээлгүй газруудын сөрөг нөлөө талаас нь судалжээ.

Судлаач Морроу “нийгмийн баялгийг бүтээхэд иргэдийн оролцоо хүүхдийн дуу хоолой, санал бодол нэн чухал бөгөөд төрийн байгууллагууд хүүхдийг аливаа асуудлын “хамтран оролцогч” буюу “үүрэг хүлээгч” хэлбэрээр хүлээн авах нь бодлогын үр дүнг өндөр түвшинд хүргэх гол хүчин зүйл” гэж онцлон тэмдэглэжээ.

### III. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Хүүхдийн сайн сайхан байдалд гарсан ахиц дэвшлийг тодорхой хугацаанд хянаж, үнэлж байх нь хотыг хүүхдэд ээлтэй болгон хөгжүүлэх үйл явцын эхний алхам юм. Үнэлгээ (assessment) нь явцын болон хэрэгжилтийн үр дүнг үнэлэх зорилгоор тодорхой арга зүйн тусламжтай хэрэгжүүлж буй үйл ажиллагаа бөгөөд үнэлгээний явцад мэдээллээ цуглуулж ашиглах, авч

хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь бодлогын зорилго, зорилтуудтай хэр нийцэж байгаа, хөтөлбөр, үйл ажиллагаа зорилтот бүлэгтээ хэрхэн хүрч байгааг тогтоох, үр өгөөжийг сайжруулахын тулд ямар өөрчлөлт хийх шаардлагатай байгаа зэргийг тодруулдаг.

Хотын хүүхдэд ээлтэй байдлын индекс тооцох үзүүлэлтүүд:

*Шалгуур үзүүлэлтүүд* нь зорилгодоо хүрэх үйл явц дахь ахиц өөрчлөлтийг эсвэл ахиц гараагүй байдлыг тодотгон харуулдаг тодорхой хугацаанд системтэй хийдэг хэмжүүр юм. Үр дүнд хүрэх явцад гарч буй ахицыг хэмжих нь суурь нөхцөл байдлыг тодорхойлох, хэмжихээс эхэлнэ. Хүүхдийн аж байдлыг хүүхдийн эрхийн шалгуур үзүүлэлтүүдийг Хүүхдийн эрхийн тухай Конвенц тодорхойлсон байдаг. Хотын хүүхдэд ээлтэй байдлыг үнэлэхдээ зургаан бүлгийн хүрээнд нийт 56 шалгуур үзүүлэлтийг ашигласан.

*Хүснэгт 1. Хүүхдэд ээлтэй байдлын индекс тооцох шалгуур үзүүлэлтүүд*

Бүлэг	Үзүүлэлтийн тоо		Нийт
	статистик	асуулга	
1.Хүүхдийн эрүүл мэнд	8	4	12
2.Хүүхдийн боловсрол	8	4	12
3.Хүүхдийн чөлөөт цагийн орчин	2	6	8
4.Хүүхдийн аюулгүй байдал	4	6	10
5.Хүүхдийн оролцоо	2	4	6
6.Хүүхдийн амьдрах орчин	4	4	8
Нийт	28	28	56

*Хүүхдэд ээлтэй байдлын индекс (The Child-Friendliness Index) тооцох аргачлал: Хотын хүүхдэд ээлтэй байдлыг үнэлж буй шалгуур үзүүлэлтүүд нь өөр хоорондоо ялгаатай хэмжих нэгжээр илэрхийлэгддэг тул тэдгээрийг нэг хэмжүүрт оруулахын тулд 1-10 онооны хооронд байх тодорхой хэмжих нэгжгүй хэмжүүр болох индекс хувиргах юм.*

Хүүхдэд нь ээлтэй байдлын индекс нь хүүхдийн эрх, тэдний сайн сайхны төлөө олон улсын болон эх газар, тивүүдийн үүрэг амлалтыг биелүүлэхийн тулд тухайн улсын засгийн газраас гаргаж буй хамгийн их хүчин чармайлтын хэмжээг тодорхойлох хэрэгсэл юм. Энэ нь хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомж, бодлогыг батлах, хүүхдийн үндсэн хэрэгцээг хангахад чиглэсэн зардал, хүүхэдтэй холбоотой үр дүнгийн ололт, амжилтыг харгалзан үзэх, тэдний оролцоог хангахад чиглэнэ. Хүүхдэд ээлтэй байдлын индексийг дараах байдлаар тооцсон. Үүнд:

I. Хотын хүүхдэд ээлтэй байдлын индексийг тооцох эхний шатанд үндсэн 6 бүлгийн 56 шалгуур үзүүлэлтийн индексийг тооцно.

*Статистик мэдээллийн хувьд:*

- а. Тухайн шалгуур үзүүлэлтүүдийг шинж чанараас нь хамааруулан эерэг ба сөрөг гэж ангилан дараах дараах томъёогоор тооцно. (Беларус улсын хүүхдэд ээлтэй байдлыг индексийг тооцох гарын авлага)

$$\text{Эерэг үзүүлэлт: } n = \left(\frac{k}{k+K_{pg}}\right) * 10 \quad \text{Сөрөг үзүүлэлт: } n =$$

$$\left(1 - \left(\frac{k}{k+K_{pg}}\right)\right) * 10$$

$k$  - Тухайн шалгуур үзүүлэлтийн хотын дүнгээр илэрхийлсэн коэффициент.

$K_{pg}$  - Тухайн шалгуур үзүүлэлтийг улсын дүнгээр илэрхийлсэн коэффициент

- б. Тухайн шалгуур үзүүлэлтүүдийн дүн, тэдгээрийн шинж чанар, нийтэд тархаасан байдал зэргээс шалтгаалан улсын дүн бус зөвхөн хотын дүнгээр илэрхийлсэн коэффициент байх тохиолдолд дараах томъёогоор тооцно.

$$n = k * 10$$

2. Судалгаагаар цуглуулсан мэдээллийн хувьд: Судалгааны үг дүнд үндэслэн индексийг дараах 2 алхмын дагуу тооцно.

- і. Судалгаанд хамрагдаж мэдээлэл өгсөн нийт хүний хариултад үндэслэн бүлгийн дундаж утгыг тооцно. Ингэхдээ судалгааны онцлог болох хариултын вариант давтагдаж буй шинж байдлыг харгалзан дунджийг жигнэсэн хэлбэрээр тооцно.

Хариултын түвшин	Хангалтгүй "1"	Дунд зэрэг "2"	Хангалттай "3"
	$x_1$	$x_2$	$x_3$
Давтамж	$f_1$	$f_2$	$f_3$

$f$  = вариант тус бүрийн давтагдах тоо буюу давтамж

Энгийн арифметик дунджийн томъёо  $\overline{x}_{\text{ариф}} = \sqrt[1]{\frac{\sum x^1}{n}}$  хэлбэртэй

байх бөгөөд жигнэсэн байдалд шилжүүлэхэд дараах хэлбэртэй

байна  $\overline{x}_{\text{ариф}} = \frac{\sum xf}{\sum f}$ .

3. Хариултын дундаж утгад үндэслэн бүлгийн индексийг тооцох. Асуулт тус бүр 3 түвшний хариулттай бөгөөд тухайн үзүүлэлтийг хангалттай сайн гэж үнэлж байгаа бол 3, дунд гэж үнэлбэл 2, хангалтгүй муу гэж

үнэлбэл 1 гэсэн хариултыг сонгоно. Үзүүлэлт тус бүрийн индексийн томъёолол дараах байдлаар бичигдэнэ.

$$n = \frac{x_{\text{ариф}}}{3} * 10$$

II. Бүлгийн дэд индекс тооцох: 6 бүлэг тус бүрт багтсан шалгуур үзүүлэлтүүдийн утгуудад үндэслэсэн индексийг геометр дунджийн аргаар тооцох бөгөөд бүлгийн индексийн томъёо  $\overline{X}_{\text{гео}} = \sqrt[n]{X_1 * X_2 * X_3 * \dots * X_n} = \sqrt[n]{\prod X}$ .  $X$  -үүд нь үзүүлэлтүүдийн индекс

III. Ерөнхий индексийн тооцох: 6 бүлэг тус бүрт тооцсон дэд индексүүдээс ерөнхий индексийг дэд бүлгийн индексүүдийг геометр дунджийн аргаар тооцно.

$$\overline{X}_{\text{ерөнхий\_гео}} = \sqrt[6]{N_1 * N_2 * N_3 * \dots * N_6} = \sqrt[6]{\prod N}$$

Энд  $N$  нь дэд бүлгийн индекс болно.


### Улаанбаатар хотын хүүхдэд ээлтэй байдлын индекс тооцсон үр дүн:

Сонгосон шалгуур үзүүлэлт, аргачлалыг ашиглан УБ хотын хүүхдэд ээлтэй байдлын индексийг тооцон гаргасан.

### Улаанбаатар хотын хүүхдэд ээлтэй байдлын ерөнхий индекс:

УБ хотын хүүхдэд ээлтэй байдлын индексийг санал болгож буй 6 бүлгийн 56 шалгуур үзүүлэлтэд тулгуурлан хэмжихэд 2015 онд 4.51 байсан бол 2019 онд **4.17** болж буурсан байна.

График 1. УБ хотын хүүхдэд ээлтэй байдлын ерөнхий индекс, 2015-2019



УБ хотын ерөнхий индексийг тооцож буй 6 бүлгийн индексийг харахад “Хүүхдийн боловсрол” бүлгийн индекс нь бусад бүлгийн индексээс өндөр байгаа нь цаашид боловсролын салбараар дамжуулан хүүхдэд ээлтэй байдлын индексийг нэмэгдүүлэх магадлалтайг илтгэж байна. “Хүүхдийн чөлөөт цагийн

орчин” бүлгийн индексийн түвшин дээрх онуудад тогтмол бусаар хэлбэлзсэн нь бодлого боловсруулагчид, хэрэгжүүлэгч нарт энэ бүлэгт багтах үзүүлэлтүүдэд анхаарлаа хандуулах шаардлагатайг харуулж байна.

Харин “Хүүхдийн эрүүл мэнд”, “Хүүхдийн оролцоо” зэрэг бүлгийн индексэд буурах хандлага ажиглагдсан нь ирээдүйд сөрөг үр нөлөө үзүүлэх тул индексийн түвшин хэт бага болон буурах хандлагатай бүлгүүдийг анхаарч түүнд төвлөрөх нь хүүхдэд ээлтэй байдлын тэнцвэрт байдлыг хангах үндэслэл болно.

График 2. УБ хотын хүүхдэд ээлтэй байдлын бүлгийн индекс, 2015-2019

Бүлэг	2015	2016	2017	2018	2019
Хүүхдийн эрүүл мэнд	3.74	3.84	4.04	4.07	3.80
Хүүхдийн боловсрол	5.10	5.33	5.28	5.48	5.76
Хүүхдийн чөлөөт цагийн орчин	5.33	4.95	5.40	5.08	5.20
Хүүхдийн аюулгүй байдал	4.18	4.22	4.19	4.17	4.35
Хүүхдийн оролцоо	5.61	5.61	5.61	3.21	3.05
Хүүхдийн амьдрах орчин	3.51	3.34	3.27	3.40	3.47

Бүлэг бүрийн индексийг 5 жилийн динамикаар харуулахад:

График 3. “Хүүхдийн эрүүл мэнд” бүлгийн индекс, 2015




График 4. “Хүүхдийн боловсрол” бүлгийн индекс, 2015-2019




График 5. “Хүүхдийн чөлөөт цагийн орчин” бүлгийн индекс, 2015-2019




График 6. “Хүүхдийн аюулгүй байдал” бүлгийн индекс, 2015-2019




График 7. “Хүүхдийн оролцоо” бүлгийн индекс, 2015-2019





График 8. “Хүүхдийн амьдрах орчин” бүлгийн индекс, 2015-2019



Бүлэг бүрийн индекст нөлөөлж буй үзүүлэлтүүдийн индексийг авч үзье.

Хүснэгт 2. “Хүүхдийн эрүүл мэнд” бүлгийн индекс, үзүүлэлтээр

Шалгуур үзүүлэлт	Индекс
1. 5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл (1000 амьд төрөлтөд)	4.80
2. 5 хүртэл насны тураалтай хүүхдийн хувь	4.09
3. 5 хүртэл насны туранхай хүүхдийн хувь	4.86
4. 5 хүртэл насны хөгжлийн хоцролттой хүүхдийн хувь	3.94

5. Өсвөр насны охидын жирэмслэлтийн коэффициент	3.78
6. Өсвөр насны охидын үр хөндөлтийн коэффициент	1.32
7. Амьсгалын замын цочмог халдварын шинж илрэлтийн коэффициент	3.16
8. Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн хүүхдийн коэффициент	1.99
9. Хотод нийтийн бие засах газрын хүрэлцээ	4.24
10. Сэтгэл зүйн зөвлөгөө авах боломж	5.68
11. Сургуулийн орчинд эрүүл хооллох боломж	6.33
12. Хүүхэдтэй илэн далангүй ярилцах байдал	5.00

### 1-10

Хүүхдийн эрүүл мэндийн 9 үзүүлэлтийн индекс дундаж (5.00) -аас доогуур байгаа ба өсвөр насны охидын жирэмслэлт, үр хөндөлт, амьсгалын замын цочмог халдварын шинж, эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн хүүхдийн тоо өндөр байна.

*Хүснэгт 3. “Хүүхдийн боловсрол” бүлгийн индекс, үзүүлэлтээр*

<i>Шалгуур үзүүлэлт</i>	<i>Индекс</i>
1. Цэцэрлэгийн хамран сургалтын хувь	7.77
2. Суурь боловсролын хамран сургалтын хувь	10.00
3. Цэцэрлэгийн 1 багшид ногдох хүүхдийн тоо	3.23
4. ЕБС-ийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	2.20
5. Цэцэрлэгийн хүүхдийн гар угаалтуурын хангамж	9.06
6. Цэцэрлэгийн хүүхдийн суултуурын хангамж	7.34
7. ЕБС-ийн хүүхдийн гар угаалтуурын хангамж	4.95
8. ЕБС-ийн бие засах суултуурын хангамж	7.50
9. Сургууль дээр хичээл давтах боломж	5.53
10. Сургууль дээр эрүүл хооллох боломж	5.31
11. Сургуулийн орчны аюулгүй байдал	5.84
12. Эцэг эхчүүдийн саналыг сонсох байдал	5.71

### 1-10

Хүүхдийн боловсролын 3 үзүүлэлтийн индекс дундаж (5.00) -аас доогуур байгаа бөгөөд цэцэрлэг, сургуулийн 1 багшид ногдох хүүхдийн тоо стандарт нормоос өндөр байна. Сургууль дээр эрүүл хооллох, хичээл давтах боломж болон сургуулийн орчны аюулгүй байдал, эцэг эхийн саналыг сургуулийн удирдлага сонсох байдал хангалтгүй байна.

*Хүснэгт 4. “Хүүхдийн чөлөөт цагийн орчин” бүлгийн индекс, үзүүлэлт бүрээр*

<i>Шалгуур үзүүлэлт</i>	<i>Индекс</i>
Урлагийн тогтлолт үзсэн үзэгчдийн хувь	6.30
Музей үзэгчдийн хувь	3.93
Хүүхдийн тоглоомын талбай	5.15
Дугуйлан секцэнд хамрагдалт	5.02
Соёлын арга хамрагдалт	5.50
Зуны амралт	5.06
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тоглох боломж	5.33

Хүүхдийн чөлөөт цагийн орчны 1 үзүүлэлт индекс дундаж (5.00) -аас доогуур байна. Сүүлийн нэг жилийн хугацаанд нийт хүүхдийн ихэнх нь соёлын арга хэмжээнд оролцож чадаагүй, зуны амралтаараа хотоос гарч амарч аялаагүй гэж хариулсан байна. Судалгаанд хамрагдсан эцэг, эхчүүд амьдарч буй дүүрэгт нь тоглоомын болон спортын талбайн хүртээмж муу байдаг гэсэн байна.

*Хүснэгт 5. “Хүүхдийн аюулгүй байдал” бүлгийн индекс, үзүүлэлт бүрээр*

<i>Шалгуур үзүүлэлт</i>	<i>Индекс</i>
Бүртгэгдсэн гэмт хэрэг	3.20
Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн тоо	5.03
Гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн тоо	3.40
Зам тээврийн ослын улмаас бэртсэн хүүхдийн тоо	1.30
Нийтийн тээврийн зорчих аюулгүй байдал	6.58
Хотоор аюулгүй явах	5.38
Хүүхдийн эсрэг хүчирхийлэл	6.69
Хотоор хүүхдийн тэрэг, тэргэнцэр явах боломж	4.61
Хүүхдийн интернэтийн зөв зохистой хэрэглээ	6.33
Мансууруулах бодисын хэрэглээнд тавих хяналт	4.89

**1-10**

Хүүхдийн аюулгүй байдлын 10 үзүүлэлтээс 5 үзүүлэлтийн индекс (5.00) -аас доогуур байна. Хүүхэд авто замын осолд өртөх, гэмт хэрэгт холбогдох, хохирох байдал өндөр байна. Хотоор бага насны хүүхдийн тэргэгтэй, тэргэнцэртэй хүн явахад хүндрэлтэй, хүүхдүүд нийтийн тээврээр зорчиход аюултай гэж хариулсан байна.

*Хүснэгт 6 “Хүүхдийн оролцоо” бүлгийн индекс, үзүүлэлтээр*

<i>Шалгуур үзүүлэлт</i>	<i>Индекс</i>
Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн зарчимд нийцсэн ИТХТ-ийн тогтоолын эзлэх хувь	0.97
Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн зарчимд нийцсэн Засаг даргын захирамжийн эзлэх хувь	0.83
Хүүхдийн оролцоо	5.8
Хүүхдэд зориулсан эвент, арга хэмжээ	4.8
Хот, дүүргийн төлөвлөлт иргэний оролцоо	5.8
Хүүхдийн эрхийн тухай эцэг эхийн мэдлэг	6.1

**1-10**

Хүүхдийн оролцооны 6 үзүүлэлтээс 3 үзүүлэлтийн индекс (5.00) -аас доогуур байгаа бөгөөд УБ хотын хэмжээнд хүүхдийн асуудлаар гарсан Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн заалтад ИТХТ-ын тогтоол, Засаг даргын захирамжийн тоо цөөн байгаа бөгөөд хот, дүүргээс хүүхдэд зориулсан арга хэмжээ хангалттай зохион байгуулдаггүй байна. Судалгаанд хамрагдсан эцэг,

эхчүүдийн ихэнх нь хот, дүүргийн төлөвлөлтөд олон нийтийн оролцоо хангалтгүй гэж үзсэн байна.

*Хүснэгт 7. “Хүүхдийн амьдрах орчин” бүлгийн индекс, үзүүлэлт бүрээр*

<i>Шалгуур үзүүлэлт</i>	<i>Индекс</i>
Орон сууцны хороололд амьдарч буй өрхийн эзлэх хувь	4.33
Нэг хүнд ногдох ногоон байгууламж	1.45
Гэр хорооллын хөрсний бохирдлыг бууруулсан хувь	2.16
Амьжиргааны түвшин доогуур өрхийн эзлэх хувь	1.71
Хүүхдийн өрөө, орон зай	4.97
Усанд орох боломж	5.89
Гэрийн гаднах агаарын бохирдол	6.28
Гэрийн ойр орчмын хог хаягдал	4.98

### **1-10**

Хүүхдийн амьдрах орчны 5 үзүүлэлтийн индекс (5.00) -аас доогуур байгаа бөгөөд ногоон байгууламж хамгийн дутмаг, амьжиргааны түвшин доогуур өрхийн эзлэх хувь өндөр байна.

***УБ хотын хүүхдэд ээлтэй байдалд тулгамдаж буй асуудлууд (хамгийн хангалтгүй)- ыг авч үзэхэд:***

1. Хүүхдийн асуудлаар гарсан Засаг даргын захирамж – 0.83
2. Хүүхдийн асуудлаар гарсан ИТХТ-ийн тогтоол 0.97
3. Зам тээврийн осолд өртсөн хүүхэд – 1.30
4. Өсвөр насны охидын үр хөндөлт – 1.32
5. Нэг хүнд ногдох ногоон байгууламж – 1.45
6. Амьжиргааны түвшин доогуур өрхөд амьдарч буй хүүхэд – 1.71
7. Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн хүүхэд – 1.99
8. Хөрсний бохирдол – 2.16
9. Сургуулийн нэг багшид ногдох хүүхдийн тоо – 2.20
10. Цэцэрлэгийн нэг багшид ногдох хүүхдийн тоо – 3.23
11. Гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэд – 3.20

Хүүхдэд ээлтэй байдлын индексийг тооцсон 56 үзүүлэлтийн 50 орчим хувь буюу 26 үзүүлэлт дундаж (5.00)- аас доогуур байгаа нь Улаанбаатар хотын хүүхдэд ээлтэй байдлын ерөнхий индекс **4.17** гарахад гол нөлөөлжээ. Энэ нь УБ хотын хувьд хүүхдэд ээлтэй байдал хангалтгүй буюу 100% байх ёстойгоос 41.7%-ийг л хангаж байгааг харуулж байна. Эндээс дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- УБ хотод хог хаягдал, бохирдол их, хүүхдийн өвчлөл өндөр байгаа нь хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.
- УБ хотод хүүхэд тоглох талбай, чөлөөт цагаа өнгөрүүлэх газар, ногоон байгууламж тун дутмаг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн

орчин бүрдээгүй байгаа нь “хүүхдэд ээлтэй бус хот” болохыг харуулж байна.

- УБ хотод осол гэмтэл, хүчирхийлэл, гэмт хэргийн гаралт өндөр, хүүхдүүд олон нийтийн газар, нийтийн тээврээр зорчиход аюултай байгаа нь аюул, эрсдэлтэй хот болохыг харуулж байна.
- УБ хотын боловсролын бүх байгууллагуудад хүүхдэд ээлтэй орчин үйлчилгээг нэвтрүүлж, хүүхэд бүрт адил тэгш үйлчлэх боловсролын тогтолцоог хөгжүүлэх хэрэгцээ маш өндөр байна.
- УБ хотын засаг захиргаа иргэд, хүүхдийн дуу хоолой, санал бодлыг хүлээн авч, сонсдог, тэдний оролцоог дэмжсэн “хүүхдэд ээлтэй засаглал”-ыг хөгжүүлж, хүүхдэд чиглэсэн бодлого, хөтөлбөр, шийдвэр батлан гаргах шаардлагатай байна.

## IV. ДҮГНЭЛТ

Хүүхдэд ээлтэй хотыг хөгжүүлэх нь хүүхдийг үл ялгаварлах, эсэн мэнд амьдрах, хөгжих, оролцох эрхүүдийг хангахад чиглэсэн хүүхдийн эрхэд суурилсан загвар бөгөөд төр хүүхдийн эрхийг хэрэгжүүлэхэд дараах үүргийг хүлээж, хариуцлага үүрэх ёстой гэдгийг онцолдог.

Хүүхдэд ээлтэй хотыг хөгжүүлэх нь хүүхэд бүрийн эрхийг (эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, оролцох) хэрэгжүүлэх, хотын бодлого, төлөвлөлтөд хүүхдийн асуудлыг тусгах үйл явцыг бүх талын удирдлагаар хангах, хотын түвшинд хүүхдийн эрхийг ханган хэрэгжүүлэх ажлыг зохицуулж, идэвхжүүлэх тогтолцоог хэрэгжүүлэх явдал юм. Ингэхдээ Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн “Ерөнхий арга хэмжээ” гэсэн бүлэгт багтаасан 9 бүрэлдэхүүн хэсгийг онцгой анхаарч хэрэгжүүлэх юм. Үүнд:

1. *Хүүхдэд ээлтэй хууль эрх зүйн орчин.* Хотын хэмжээнд хүүхдийн эрхийг хамгаалсан, түүнийг хөхиүлэн дэмжсэн хууль эрх зүйн орчинг бүрдүүлж, түүнийг бүх нийтээр даган мөрддөг байхыг чухалчилдаг. Хотоос хүүхдийн асуудлаар шийдвэр гаргахдаа хүүхдийн эрхийн мэдрэмжтэй хандаж, тэдний хэрэгцээ шаардлагыг анхаарч үзэх бөгөөд боловсруулан гаргаж байгаа аливаа хууль, дүрэм журам, эрх зүйн баримт бичигтээ хүүхдэд хамаарал бүхий асуудлыг дэмжиж тусгасан байх ёстой.

2. *Хотын хэмжээнд хүүхдийн эрхийг хангах бодлого, стратеги.* Хүүхдэд ээлтэй хотын бодлого, төлөвлөгөө нь “Хотын хэмжээний хүүхдийн эрхийг хангах стратеги төлөвлөгөөнд үндэслэнэ” гэсэн үг бөгөөд “Хүүхдийн эрхийг хангахуйц орчин, үйлчилгээ, үйл ажиллагааг бий болгоход өөрийн гэсэн бодлого, хөтөлбөр, тодорхой зорилго, үйл ажиллагааны чиглэл, хүлээгдэж байгаа үр дүн зэргийг гаргана” гэсэн үг юм. Хүүхдийн эрхийг хангасан бодит

үзүүлэлт нь тэдний амьдралд бодитой гарч байгаа өөрчлөлт, ахицаар тодорхойлогдоно.

3. *Хүүхдийн эрхийг хамгаалах үйл ажиллагааг зохицуулах бүтэц, механизм.*

Хотын түвшинд

хүүхдэд ээлтэй хотыг хөгжүүлэх нэг гол шаардлага нь хүүхдийн асуудлыг хотын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн төвд байлгах явдал бөгөөд үүнийг ажил хэрэгжүүлэх арга нь эрх мэдэл бүхий, дээд түвшний зохицуулах нэгжийг байгуулж ажиллах явдал юм.

4. *Хүүхдэд үзүүлэх үр нөлөөний үнэлгээ, хяналт шинжилгээ.* НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос аливаа үйл ажиллагааны үр нөлөөг үнэлэх үндэсний тогтолцоог бий болгож ашиглахыг зөвлөсөн. Тухайлбал, ялгаварлан гадуурхалтаас ангид үйл явц гэдэг нь хууль эрх зүй, бодлогын орчинд нөлөөлөхдөө хүүхэд, тэр тусмаа эмзэг бүлгийн хүүхдүүдэд яаж хүрч байгаад үнэлгээ хийж дүгнэнэ гэсэн үг.

5. *Хүүхдэд чиглэсэн төсөв, хөрөнгө оруулалт.* ХЭК-д “Улс орнууд хүүхдийн эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг баталгаажуулах ажилд шаардлагатай хөрөнгө нөөцийг хангалттай хэмжээгээр дайчлах, хуваарилах ёстой” гэжээ. Хүүхдэд зарцуулах хөрөнгийн хэмжээг төсвийн зүйл, заалт бүрээр хийсэн нарийвчилсан үнэлгээ, эдгээр нь хүүхдийн аж байдлыг сайжруулахад ямар үр нөлөө үзүүлж болохыг тодорхойлсон нэгдсэн үнэлгээ заавал хийгдсэн байх шаардлагатай.

*Хотын хүүхдийн аж байдлын тухай тайлан.* Хүүхдэд ээлтэй хот нь тэнд амьдарч буй бүх хүүхдийн аж байдлыг байнга хянаж байх үүрэгтэй. Хүүхдийг төрснөөс нь эхлээд 18 нас хүртэл нь холбогдох мэдээ, тоо баримтыг цуглуулж, дүгнэлт хийж байх нь хүүхэд төвт бодлогын орчныг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой.

6. *Хүүхдийн эрхийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголт.* Хүний эрх, тэр тусмаа хүүхдийн эрхийн талаар мэдэж байх хэрэгтэй гэдэг ойлголт, хандлага маш чухал юм. Хүүхдэд ээлтэй хотод хүүхдүүд эрх тэгш иргэн гэдэг утгаараа хүүхдийн эрх нь тэдэнд болон тэдэнтэй ажилладаг хүмүүст эн тэргүүний амин хэрэгцээ болж тавигдах ёстой.

7. *Бүх талуудтай хамтран хүүхдийн сайн сайхны төлөөх нөлөөлөл, ухуулга, сурталчилгаа.* Хүүхдийн эрхийг сурталчлах, дэмжихэд хүний эрхийн бие даасан байгууллагыг хөгжүүлэх, ТББ-ын оролцоог дэмжиж, хэн нэгнээс хараат бус, хүүхдийн эрхийг хангах үйл явцад хөндлөнгийн хяналт тавьж, шаардлагатай үед хүүхдийн дуу хоолойг илэрхийлдэг байх нь хамгийн чухал.

8. *Хүүхдийн оролцоо.* ХЭК-ийн 12 дугаар бүлэгт заасанчлан хүүхдийг сонсох, тэдний санаа бодлыг бодлогын шийдвэрт заавал тусгах асуудлыг хуульчилж өгснийг үндэс болгох юм.

Хүүхдэд ээлтэй хот байгуулах үйл явцын үндсэн тулгуур нь улс төрийн дэмжлэг, Засгийн Газрын байгууллагуудын нэгдмэл хамтын ажиллагаа юм. Хотын засаг захиргаа ирээдүйтэй төлөвлөгөө гаргахын тулд хүүхэд, залуучуудыг хотын бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд оролцуулж, санал авдаг болох нь аажимдаа хүүхэд төвт бодлого, эрх зүйн орчинг бүрдүүлэхэд чухал түлхэц болно. Хүүхдэд ээлтэй хотыг хөгжүүлэх нь “Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц” санаачлагын бүрэлдхүүн хэсэг болохынхоо хувьд хүүхдийн эрхийг засаглалын бүх түвшинд хэрэгжүүлэх, улмаар “Тогтвортой хөгжлийн зорилго”-ын хүрээнд хүлээсэн үүргээ биелүүлэхэд хувь нэмрээ оруулах юм.

**НОМ ЗҮЙ:**

1. *Ранжит Кумар, Судалгааны арга зүй (2019)*
2. *Солеман Х. Абу-Бадер, ШУА, Философи, социологийн хүрээлэн, (2013). Нийгмийн ажлын практикт статистик арга хэрэглэх нь*
3. *ШУА, Философи, социологи, эрх зүйн хүрээлэн. Хотын социологи, УБ 2012*
4. *Child friendly cities-Children’s Environments: [childfriendlycities.org](http://childfriendlycities.org)*
5. *Friendly citiesJudith Wilks, Child Friendly cities: Place for avtive citizenship in geographical and environmental education (2010)*
6. *Geoffrey Woolcock (2010) Urban research and childfriendly cities: a new Australian outline*
7. *Kingston, (2007). Creating in friendly cities: The Case of Denver USA*
8. *Innocenti Research Centre , (2004). Building Child Friendly Cities*